

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт						
Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг						
2022 оны хагас жил						
Шийдвэр ийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
<b>МУ-ын хууль</b>						
8	9	Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-01-29 Дугаар 2015.01.29	9.4.. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаа:G39аажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.	ЭМС-ын 2022 оны А/139 дүгээр тушаалд батлагдсан "Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношлогоог зохион байгуулах " журмын дагуу ӨАГТМЭ-т эмэгтэйчүүдийн хөхний үзлэг, зүрхний бичлэг, цээж гэрэлд харуулах, дотрын эмчийн үзлэг оношилгоо шинжилгээг тогмол үр дүнтэй зохион байгуулж сэжигтэй тохиолдлуудыг ХСҮТ-ийн эмч нарт илгээх эрсдэлтэй болон үрэвсэлтэй тохиолдлуудыг эмэгтэйчүүдийн үрэвслийн мэс заслын тасагт илгээж эмчилгээ үйлчилгээг явуулж байна. Мөн ЭМДТ-ийн өдрийн эмчилгээнд хамруулан эмчилгээ үйлчилгээг хийж байна.	80%	Хүлээн авах тасгуудыг нэгтгэн засвар хийхтэй холбогдуулан хөхний кабинетийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон. Хөхний чиглэлд мэргэшсэн эмч гадаад улсад сургалтанд явсан тул хөхний үзлэг 100% биелэлтгүй байсан. Бусад үзлэг илрүүлэх хэвийн хийгдэж байна.
10	12	Эрүүл ахуйн тухай 2016-02-04 Дугаар 2016.02.04	4.5.. Энэ хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. (4.4.2.хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах;)	Өргөө амаржих газар нь ЭМС-н А/505 тоот тушаалын хэрэгжилтийг ханган эмнэлгийн хог хаягдлыг аюултай болон энгийн гэж өнгөөр тэмдэглэж хогийг үүссэн цэг дээр нь ангилан ялгаж байна. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг зүүнд хатгагдах эрсдэлээс сэргийлэн зүү авагчийг 2022 оноос эхлэн үйл ажиллагаандаа хэрэглэж байна.Тус амаржих газар аюултай хог хаягдлаа “Элемент”ХХК-тай хийсэн гэрээний дагуу тээвэрлэж устгалд оруулдаг.	100%	Үйл ажиллагаа доголдолгүй тогтмол хийгдэж байна.

13	19	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12	14.2.2.. эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах;	Эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр хөхөөр хооллолтыг дэмжих дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, эхчүүдэд 7 хоног бүр сургалт мэдээлэл өгдөг.	97%	Гүн дутуу болон хооллолтын бэрхшээлтэй нярайг хөхөөр хооллох боломж хомс байх тохиолдол үүсдэг.
	20		15.3.. Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хөхний сүүний банк байгуулахаар байгууллагын стратеги төлөвлөгөөнд оруулж батлуулсан ба төсөл боловсруулах шатанд явж байна.	40%	Байгууллагын 3 жилийн стратеги төлөвлөгөөнд оруулж батлуулсан.
	21		18.2.. "Энэ хуулийн 14.6.3-т заасан үнэлгээг хийх заавар, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай хамтран батална. /14.6.3-т хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн шийдвэр болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний тухай Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулах/"	Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн шийдвэр, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийсэн ба тус эмнэлэгт хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 85% байна. Хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор эхийн хөхний сүүний ач холбогдлыг ойлгуулах сургалт мэдээлийг тогтмол олгож байна.	85%	Хүүхэд бүрийг хөхний сүүгээр хооллох, хөхний сүүний банк байгуулахаар байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

15	23	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	"Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 2022-2025" -ийг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.	80%	Коронавирусын эсрэг дархлаажуулалтын давтан тун, В С вирусын илрүүлэг шинжилгээ, эмгэг төрөгч илрүүлэх шинжилгээнд нийт ажилтнуудыг хамрагдуулсан. 2022 оны хоёрдугаар хагас жилд дотрын эмчийн үзлэг шинжилгээнд хамруулахаар зорин ажиллаж байна
	38		7.1.4.. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	2022 оны эхний хагас жилд нийт 1,8 тэрбумын хөрөнгө оруулалт орсоноос: Төсвийн хөрөнгөөр 11,7 сая төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 1,6 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 92,8 сая төгрөгийн түргэн тусламжийн автомашин, мөн аж ахуй нэгж иргэдийн хандиваар 96,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байна.	100%	96.8 сая төгрөгний автомашин байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэгдэн орж ирсэн

	40	7.1.11.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	2022 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй цар тахалтай холбоотой урьдчилан сэргийлэх, тэмцэх ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэн Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар болон бусад албан ёсны холбогдох байгууллагаас гаргасан цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар Байгууллагын албан ёсны веб сайт <a href="https://urguu-amarjikh.ub.gov.mn/">https://urguu-amarjikh.ub.gov.mn/</a> 26 мэдээлэл, Нийслэлийн Өргөө амаржих газар фейсбүүкийн хуудсаар 26 мэдээллийг иргэдэд хүргэж нийт 36100 хандалттай байна.	70%	2022 оны 01 сарын 2-оос 2022 оны 03 сарын 10-ны хооронд 7 хоногт 4-5 удаагийн давтамжтай 26 мэдээллийг байршуулсан. Нийт хандалтын тоо /Нийслэлийн Өргөө амаржих газар/Фейсбүүк хуудас-36100 хандалттай. <a href="https://urguu-amarjikh.ub.gov.mn/">https://urguu-amarjikh.ub.gov.mn/</a> веб сайт-157400 хандалттай
	44	7.1.16.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	Өргөө амаржих газрын захиралын 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн Б/89 тоот "Коронавируст халдварын голомтот бүсэд ажилласан ажилтнуудын үндсэн цалинг 50 хувиар өсгөж олгох тухай" тушаалаар голомтот бүсэд 2022.01.12-2022.01.31-ний өдрийн хооронд ажилласан 54 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд нийт 19'473'654 төгрөгийн цалин хөлс тооцож олгосон.	100%	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох тухай хуулийн хэрэгжилт хангасан.

	48	7.1.23.. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./	2022 оны эхний хагас жилээр цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тогтмол явуулж, ажилчдыг 3 тунт вакцинд 100% бүрэн хамруулж, хамгаалах хэрэгсэлээр бүрэн ханган ажилласан.	100%	Цар тахлын үеийн эм эмнэлгийн хэрэгслийн бүрэн хангаж ажилласан.
	50	9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС-н 2022 оны 01 сарын 18-ны А/33 тоот тушаал “Шинэ коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай”, 2022 оны 01 сарын 19-ны А/36 “Түр заавар батлах тухай” тушаалуудыг үндэслэн Өргөө амаржих газрын даргын 2022,01,18-ны өдрийн А/08 “Коронавируст халдварын тархалт буурсантай холбоотой 180 ор буулгах, гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийх тухай” тушаалыг гарган үйл ажиллагаандаа хэрэглэж байна.	80%	ЭМС-н тушаалын дагуу байгууллагын захирлын тушаал гаргасан.
	51	9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./	Эм зүйн алба нь нийт 240 сая 265 мянган төгрөгний өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг 2 сарын нөөцтэйгөөр хадгалалтын дэглэм алдалгүй нөөцлөж байна. Үүнд : Эм- 108 нэр төрлийн-102 сая 981 мянга,Эмнэлгийн хэрэгсэл-189 нэр төрлийн 128 сая 172 мянга, Ариутгал халваргүйтгэлийн бодис-11 нэр төрлийн 9 сая 112 мянган төгрөг байна.	90%	Нөөцийн хомсдол үүсгэлгүй ажиллаж байна.
<b>УИХ-ЫН ТОГТООЛ</b>					

	57	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг	<p>1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэргэжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"- ний хүрээнд</p> <p>1. ХБИргэдтэй харилцах, тэдний эрхийг дэмжих, тусламж үзүүлэх тухай сургалт хийх, 2. харилцах дохионы хэлэнд сургах, 3. эмнэлэгт үйлчлүүлэх орчин, аюулгүй байдлыг хангаж ажиллахын тулд бие засах өрөөг тохижуулах, хэрэглэх таяг, ханын бариул, тэргэнцрийг бэлтгэн байршуулах, эмнэлгий ажилтнуудад энэ талаар мэдээлэл өгч хэрхэн хэрэглэж ХБИргэдэд туслах талаарх сургалт хийсэн. Үүнд:</p> <p>1. нийт 78 эмч эмнэлгийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны ерөнхийлөгч, сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал М.Ганзоригийн урьж "Хөгжлийн бархшээлтэй иргэдтэй хэрхэн харилцах аргазүй, хэрхэн дэмжиж туслах" сургалт хийсэн. 2021.09.29</p> <p>2. Сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцахын тулд хэргэлэх дохионы хэлний үсэг, хэрэглэх зааварчилгаа бүхий гарын авлагыг бэлтгэж бүх тасаг, хэсгийн сувилагчийн постон дээо байршуулсан. 2022.01 сар</p> <p>3. Мэс заслын дараах төрсөн эхчүүдийн тасагт ХБНГУ-ын тусламжийн төслийн санхүүжилтээр тоногосон бие засах өрөө, ханын бариул, таяг, тэргэнцрүүдийг бэлтгэн байршуулж тэдгээр хэрэгслүүдийн хэрэглээ, байршил, хүндээ хэрхэн хүргэжбгч, туслах талаар мэдээлэл өгч сургаж</p>	70%	Жил бүр сургалт, сурталчилгаа, мэдээлэл өгдөг тогтсон төлөвлөгөөний дагуу хийгдсэн. Цар тахалтай холбоотой урьд онуудтай адил түвшинд хэргэжүүлэх боломжгүй байсан.
--	----	---	---	--	-----	---

23	58	хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ӨАГТМЭ-т дараах ажлууд тогтмол чанартай хүртээмжтэй тасралтгүй хийгдэж байна. 1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ээлтэй эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлсэн. - стандартад заасан налуу зам - Ариун цэврийн өрөө - Кордиорт бариул 2.Шаардлагатай туслах хэрэгслээр хангах - Тэргэнцэр - Тулгуур таяг - Автомат үзлэгийн ор - Төрөх өрөө болон амбулаторийн хэсэгт байрлуулсан. 3. Хөтөч сувилагч, дохионы хэлний сургалтанд хамрагдсан сувилагчаар тусгайлан үйлчилгээг үзүүлдэг. 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний " Хөх үнэмлэхийг" үндэслэн хүлээгдэл чирэгдэлгүй,	85%	Эмнэлгийн хананд аюулгүйн бариул бүрэн суурьлуулагдаагүй. Эмнэлгийн зохион байгуулалтаас шалтгаалж зарим хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зай талбай бүхий ариун цэврийн өрөө хийгдэх боломжгүй байна.
	59		1.4/г/. эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцүүлэх.	Жил бүр байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль конвенцид заасан зохицуулалттай нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг хүлээлцэх, таних, төрөлтийн болон өвчтөний түүхэнд тэмдэглэгээг хийхийг дотоод журманд тусган мөрдлөг болгон ажиллаж байна.	75%	Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг бүрэн таних ур чадвар бүхий бэтгэгдсэн ажилтан дутмагаас шалтгаалж зарим үйлчлүүлэгчдийг танин тодорхойлж тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэх боломж хомс байна.

24	60	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21	Нэг.1/. хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх; (Нэг.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:)	Герман улсын элчин сайдын яам болон Ийм-Болгоё төрийн бус байгууллагын 100% санхүүжилтээр Төрөх төрсний дараах тасгийн 4 давхарын ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж үйлчлүүлэгчдийн ая тухтай орчныг бүрдүүлсэн. Мөн дотоодын аж ахуй нэгж байгууллагууд болох Таван Богд ХХК, Unitel ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор эмнэлгийг бүрэн интернет сүлжээнд холбож ажилласан.	90%	Дотоодын томоохон аж ахуй нэгж байгууллагуудаас санхүүгийн дэмжлэг бүрдүүлж чадсан.
26	68	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39	1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Тус амаржих газрын 2021 оны жилийн төсвийн гүйцэтгэлд хийгдсэн аудитын дүгнэлтээр 3 зөрчил заагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022.06.30-ны өдөр Эрүүл мэндийн яаманд хүргүүлэв.	100%	Зөрчлийг бүрэн арилгаж ажилласан
	75		1.1.д/. халдвар авсан иргэдэд гэрийн тусгаарлалтад байх хугацаанд эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээг үнэн зөв, шуурхай хүргэх, өвчнийг эмчлэхэд шаардлагатай эмийн төрөл, хэрэглэх тун, заавар, мэдээллээр бүх иргэнийг тэгш, хүртээмжтэй хангах; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	2022 оны эхний хагас жилийн байдлаар коронавирусын халдвартай 613 үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн хэвтэн эмчлүүлсэн байна. Эдгээр үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарсны дараа үргэлжлүүлэн гэрийн тусгаарлалтанд шилжүүлэн ажилласан.	85%	Амаржих газарт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийг эмнэлгээс гарангуут өрхийн эмчийн хяналтанд шилжүүлж ажилласан



	77		1.1.ё/. цар тахлын үед иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр шуурхай, баталгаатай эдлүүлэх бүх боломж нөхцөлийг бүрдүүлж, халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамаарч төрийн үйлчилгээ авах эрхийг хязгаарлахгүй байх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	2022 оны эхний 5 сарын байдлаар харьяалал харгалзалгүй нийт 10650 үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	90%	2022 оны 01 сараас эхлэн үйлчлүүлэгчийг харьяалал харгалзахгүй хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна
<b>ЗГ-ын тогтоол</b>						
	145		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын <u>дотоод журамд тусган хориглож, зөрчсөн</u>	Байгууллагын дотоод журамд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох заалтыг оруулсан. Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн 1 ажилтны зөрчлийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцээд хөдөлмөрийн гэрээг цуцлах арга хэмжээ тооцсон.	100%	Байгууллагын дотоод журмыг шинэчлэн батлаж, журмын хэрэгжилтийг хангах үүднээс дотоод хяналт шалгатыг сайжруулан үүссэн зөрчлийг илрүүлэн арилгасан.
	146		1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн 5 зөрчлийг ёс зүйн хороо, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, 2 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, 2 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулж, 2 удирдах ажилтанд хугацаатай үүрэг, 1 ажилтанд зөвлөмж хүргүүлж, биелэлтийг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж хариуцлага тооцон ажилласан.	100%	Дотоод хяналт шалгалтыг сайжруулан зөрчил доголдлыг илрүүлэн ажиллаж нийт ажилтнуудад хуулийн эрх зүйн мэдлэг олгох ажлын байрны сургалт хийсэн.

	147		1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу хурууны хээгээр бүртгэх хэлбэрийг зогсоож, бүртгэлийг хүний нөөцийн алба нэгтгэн дотоодын хяналт тавин ажиллаж байна.	80%	Нүүр таних төхөөрөмжийг ашиглахаар бэлтгэж байна.
	148		1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгайлан ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар заалт оруулж, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр байгууллагын соёл, харилцаа хандлага сэдвээр 6 удаа давхардсан тоогоор нийт 734 ажилтанд 12 цагийн танхимын сургалт, мэдээллийг зохион явуулсан.	80%	Дотоод хяналтаар байгууллагын үйлчилэгч, асрагч нарын 34 хүнтэй ажлын байрны ганцаарчилсан уулзалтыг явуулж дүн шинжилгээ хийж цаашидавч хэрэгжүүлэх ажиларга хэмжээг төлөвлөж байна.
	149		3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Байгууллагын дотоод журмын биелэлтийг сайжруулах, дэг журмыг хангах, үйлчлүүлэгчидтэй харилцах харилцааг дэмжих зорилгоор дотоод хяналтыг тогтмол явуулж, эхний хагас жилийн хугацаанд бүх тасаг нэгжээр 114 удаа тойрон үзлэг хийж, нийт илэрсэн 35 үл тохирлыг газар дээр нь арилгуулж ажиллав.	50%	дотоод хяналтыг биечлэн явуулснаар Иргэдээс тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл гомдол урд оны мөн үеэс 3 нэгжээр буурсан байна.

61	161	Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359	4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтын дагуу хагас жилийн байдлаар бараа ажил үйлчилгээ худалдан авах 6 төрлийн тендер зарлагдана. Үүнээс хуваарийн дагуу 4 тендерийг зарлаж 1 тендер гэрээ байгуулах шатанд, 2 тендер үнэлэх шатанд, 1 тендер дахин зарласан, хүлээгдэж буй 2 тендер байна.	70%	Хуваарийн дагуу 4 тендер амжилттай зарлаж 1 тендер гэрээ байгуулах шатанд /90%/, 2 тендер үнэлэх шатанд /70%/, 1 тендер дахин зарласан /50%/. Хуваарийн дагуу 8, 9 дүгээр сард зарлагдах 2 тендерийн бэлтгэл ажлыг хангаж
65	166	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	2022 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтанд хамруулах зардлыг эцэслэн батлаагүй. 2022 оны хоёрдугаар хагас жилд эцэслэн батлаж 2023 оны төсвийн төсөлд тусгах саналыг тусгана	10%	Төрийн албан хаагчийн сургалтанд хамрагдах хүний нөөцийн судалгааг гарган ажиллаж байна..

66	167	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 2022 онд 4 сард байгууллагаас санаачилсан олон улсын онол практикийн хурлын үйл ажиллагааг хамтран ажилладаг байгууллагуудаас ивээн тэтгэгчдийн төсвөөр зохион байгуулж 120 хүн танхимаар, 150 хүнийг цахимаар хамруулсан төсөв хэмнэсэн арга хэмжээ болсон. 06.27 нд гадаад орнуудтай хамтын ажиллагааг сэргээх зорилгоор цахим уулзалт хийж ажилласан. ЭХЭМҮТ, ЭСҮТ-с зохион байгуулсан мэргэжлийн сэдэвт 3 сургалтанд эмч, эмнэлгийн ажилтнууд цахимаар холбогдон оролцож байна. Амаржих газрын хүрээнд эмч нарт сургалтыг цахим хуудсан дээр сэдэв, агуулагдхууныг мэдээлж шаардлагатай эмч ажилтныг хамруулж хийж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Засгийн газрын тогтоолын 1.4.-д тусгасан заалтаар төсвөөс хөрөнгө зарцуулалт хийгдээгүй болно.	80%	Бүх хурал зөвөлгөөн бүрэн цахимжих боломжгүй, зайлшгүй гардан сургах, үзүүлэх шаардлага байгаа
<b>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</b>						
72	176	2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2018-11-28 Дугаар 2018_49	2.5. жолооч нарт гүйцэтгэсэн ажилд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, эмнэлгийн байнгын тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт;	2022 оны эхний хагас жилийн байдлаар жолооч нарт 17.6 сая төгрөгийн цалин нэмэгдэл хөлс олгосон байна. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан.	100%	Хууль тогтоомжинд тусгасны дагуу цалин урамшууллыг бүрэн олгосон.

87	197	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	2. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээг тэмдэглэсэн өвчний түүхийг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим мэдээллийн сан бий болгох асуудлыг судлан үзэж, холбогдох арга хэмжээ авах.	Бүх шатны эмнэлэг болон эмийн сангуудад ашиглах боломжтой Аксис ХХК -ийн: 1.Лаборатори удирдлагын систем 2.Захиалга удаирдлагын систем 3.Цахим түүхийн систем 4.Тайлангийн нэгдсэн систем 5.Эмнэлгийн удирдлагийн систем 6.Хүний нөөцийн зэрэг нийт 6 багц 84 дэд цогц системийг 2022 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн 5-н сургагч багш 14 хоногийн хугацаанд ажиллаж манай байгууллага хэрэгжүүлж эхэлсэн. Карте програмыг ашигласнаар бүрэн цахимд шилжих боломжтой болсон. Цаашид И-монголиа системтэй холбогдож онлайн цаг захиалах боломжтой болгохоор зорин хөгжүүлэгч талтай хамтран ажиллаж байна.	100%	Эмнэлгийн хэмжээнд тогтоол шийдвэрийг ханган ажиллаж байна гэж дүгнэж байна
	211		ХҮ.13.6. “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад;	Худалдан авах ажиллагаа болон гэрээ гэрээний биелэлтийг тухай бүр нь иргэд олон нийтэд цахим хуудсанд мэдээ мэдээллийн талаар байршуулан ажиллаж байна.	100%	Жил сар улирал тухай бүр байгууллагын худалдан авсан бараа ажил үйлчилгээ болон орлого зарлагын талаар мэдээлэл цахим хуудсанд байршуулж байна

102	218	<p>2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11</p>	<p>XIX.1. . Коронавируст халдварын дараахь нөхөн сэргээх эмчилгээг эрчимжүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг энэ оны 5 дугаар сарын 1-ээс эхлэн орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин нарт тус тус даалгав;</p>	<p>Ковид-19 халдварын нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 2022 оны 1,2 дугаар сард 200 ор дэлгэн ажиллах үед давхардсан тоогоор ковид-19 халдвар бүхий нийт 3440 үйлчлүүлэгчид Норов-7 танг буцалган найруулж утлага эмчилгээтэй хавсран хийсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Сэргээн засах уламжлалт эмчилгээний тасаг нь амбулатор болон өдрийн эмчилгээний нэгжийн байдлаар пост ковидын шинж тэмдэг илэрсэн болон бусад эх барихын, эмэгтэйчүүдийн эмгэг бүхий нийт 8358 хүнд үйлчлээд байна. Сэргээн засах тусламж үйлчилгээний нэг төрөл болох сэтгэл зүйн зөвлөгөөг нийт 168 үйлчлүүлэгчид өгөөд байна. Цаашид хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хүндрэлээс сэргийлэх зорилгоор эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөн сэргээн засах тусламж үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх тасаг нээхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	95%	<p>Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед эмнэлгийн нөөц бололцоог ашиглан сэргээн засах уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлсэн. Цаашид ковид -19 болон бусад эмгэгийн улмаас үйлчлүүлэгчид үүсэх чадвар алдагдалыг багасгаж, амьдралын чанарыг сайжруулах, хүндрэлээс сэргийлэх зорилгоор сэргээн засах уламжлалт эмчилгээний тасаг нээн ажиллуулахаар бэлтгэлийг хангаад байна.</p>
	221		<p>Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.</p>	<p>Өргөө амаржих газрын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс албан тушаалтанд- 23 , Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж 3 гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэж, хариуг утсаар болон албан бичгээр хүргүүлсэн байна. Өргөдөл гомдлын 45.6 хувь нь эмчилгээ үйлчилгээ, 45.6 хувь нь эмч ажилтнуудын харьцаа хандлага, ёс зүйтэй холбоотой байсныг шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг-2, зөвлөмж-1, сургалт мэдээлэл 6 удаа зохион байгуулж ажилласан.</p>	80%	<p>Санал гомдолтой холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Зарим эмчилгээ үйлчилгээний мөрдөгдөх журамд дотоод аудит хийж шинэчлэх ажил 80% гүйцэтгэлтэй яваглаж байна.</p>

105	223	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	ХҮИИ.2.1. Хүүхдийн өвчлөлийн нөхцөл байдал, тусламж, үйлчилгээний хүрэлцээ, орны нөөц, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудын хүүхдийг хэвтүүлэн эмчлэх орыг шинэчлэхэд шаардагдах зардлыг 2023 оны төсвийн төсөлд тусгах талаар судалж, холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав;	Нярайн ор 15 ширхэг, дулаацуулах ширээ 8 ширхэг, нярайн үзлэгийн ор 5 ширхэг, хяналтын монитор 3 ширхэг, фотоаппарат 8 ширхэг захиалж төсөвт суулгасан.	75%	Захийлсан тоног төхөөрөмжийн 50%-ийн хангалт хийгдсэн.Зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг авах ажил төслийн шатанд явагдаж байна. /50%/
<b>ЗГ-ын албан даалгавар</b>						
110	237	Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03	1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах.	"Цахим төлбөрийн баримтын систем" /e-barimt/ нэвтрүүлэх ажлыг өөрийн байгууллагад бүрэн нэвтрүүлэн иргэдэд чиргэдэл учруулахгүй ажиллаж байна." өргөө амаржих газар" төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт үйчилүүлж байгаа иргэдэд /e-barimt/-ыг бүрэн хэвлэн өгч хэвшсэн.	100%	Цахим төлбөрийн баримтыг төлбөр тооцоо хийсэн даруйд нь хэвлэж өгч байна. Иргэдэд хурдан шуурхай үйлчилж байна
	238		1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах.	Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор цахим үйлчилгээний 2 ажилтан сургаж, цахим системийн талаар иргэдэд сурталчлан таниулах өдөрлөг зохион байгуулсан.	100%	Цахим систем нэвтрүүлэн ажиллаж байна.
	239		1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, цахим шилжилтийн бодлогын хүрээнд "Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн гүйлгээг Эрхийн бүртгэлийн сан системийг ашиглан цахимаар баталгаажуулах" сургалтанд хамрагдан цахим системээр гүйлгээ хийгдэж байна.	100%	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн гүйлгээг Эрхийн бүртгэлийн сан системийг ашиглан цахимаар хийсэн

	250		1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг фейсбүүкийн хуудсаар болон <a href="https://urguu-amarjikh.ub.gov.mn/">https://urguu-amarjikh.ub.gov.mn/</a> цахим хуудсаар дамжуулан шаардлагатай тохиолдолд телевизүүд, албан ёсны мэдээллийн сайтуудтай хамтран төрийн үйлчилгээний талаар мэдээллийг цаг тухай бүрт нь нийтэд сурталчлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Ажлын байрны нээлтэй зар- 56 ажлын сонгон шалгаруулалтыг зарласан. Нийт хандалтын тоо 86523 Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл-106 төрлийн мэдээлэл байршуулсан. Хандалтын тоо- 306785 Ил тодын мэдээлэл, Худалдан авах ажиллагаа-5 мэдээлэл	90%	2022 оны 01 сарын 2-оос 2022 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар 7 хоногт фейсбүүкийн хуудас болон веб сайтаар 15-20 удаагийн давтамжтай мэдээлэл байршуулсан. Нийт хандалтын тоо-Давхардсан тоогоор 402600
	251		1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн системд ашиглахтай холбоотойгоор 2021 оны 12 сарын 21-ны өдрөөс эхлэн Эйблсофт ХХК компанитай гэрээ байгуулан дээд шатны байгууллагууд болон бусад эмнэлгүүд хооронд албан бичиг цахимаар солилцон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	50%	Албан бичиг солилцох үйл ажиллагаанд ажилтанд тодорхойлолт гаргах болон хувийн хэвшлийн байгууллагууд нэгдсэн системд хамрагдаагүй байдаг тул цаасаар албан бичиг болон хариу хүргүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байгаа юм.
ХЯНАСАН: ЭМЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ			С.АЛТАНТУЯА			
БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ДЭМЖИХ АЛБАНЫ ДАРГА			Н.ПҮРЭВЖАРГАЛ			